



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/118

Сангийндалай

Техникийн хяналтын улсын үзлэг, тээврийн
хэрэгслийн шинэчилсэн бүртгэлийг
явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.19 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрдэнэдалай сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллага, иргэдийн эзэмшилд байгаа бүх төрлийн автотээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, техникийн хяналтын улсын үзлэг, оношилгоо, албан татвар, төлбөр хураах ажлыг 2023 оны 06 дугаар сарын 06-13-ны өдрүүдэд Эрдэнэдалай сумын төвд зохион байгуулсугай.

2. Автотээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, техникийн хяналтын улсын үзлэг, тооллого, албан татвар, төлбөр хураах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	А.Соёл-Эрдэнэ (Санхүүгийн албаны дарга)
Гишүүд:	Ж.Бадамцэцэг (Төрийн сангийн мэргэжилтэн)
	Ж.Хишигсүрэн (Нягтлан бодогч)
	Ч.Гантөгс (Улсын бүртгэлч)
	Д.Цогбадрах (1-р багийн Засаг дарга)
	Н.Гансүх (2-р багийн Засаг дарга)
	О.Базаррагчаа (3-р багийн Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Д.Мөнхбаатар (4-р багийн Засаг дарга)
	Д.Ууганбаяр (5-р багийн Засаг дарга)
	Ж.Өлзийжаргал (6-р багийн Засаг дарга)
	Ж.Түвшинбаатар (7-р багийн Засаг дарга)
	Л.Лхагвагарам (Цагдаагийн хэсгийн дарга)
	Б.Энхтөр (Эрэн хайх, аврах салбарын дарга)

3. Техникийн хяналтын үзлэг, тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, оношилгоо, албан татвар, төлбөр хураалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ЛХАГВАМАНДАЛ

482302235